ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 14 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022 /91/ НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Орхон аймаг
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас:70359826
Цахим хаяг:orkhon@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас:70355805
Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn
Аудитор: Ж.Наранчимэг
Утас:70359826
Цахим хаяг:naranchimegj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ........................................ 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................ 2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........................................ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ...................... **Error! Bookmark not defined.**
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................ 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан............................ **Error! Bookmark not defined.**
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................ 10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................ 10
3. Аудитын тайлан........................................ 12
3.1 Ерөнхий зүйл........................................ 12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................ 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................ 13
3.4 Материаллаг байдал ........................................ 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........................................ 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........................................ 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........................................ 15
3.8 Аудитын гол асуудал ........................................ 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ................. 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........................................ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................ 16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................ 16
4. Аудитын илрүүлэлт ........................................ 16
4.1 Залруулсан алдаа ........................................ 16
4.2 Төлбөрийн акт ........................................ **Error! Bookmark not defined.**
4.3 Албан шаардлага ........................................ 16
4.4 Зөвлөмж........................................ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ......................... **Error! Bookmark not defined.**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгэ худалдан авах тухай хууль |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| АО | Ажил олгогч |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын код: ОРА-2022 /91/ НА-СТА-ТШЗ

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 58

танай ____________ -ны № ____________ -т

ОРХОН АЙМГИЙН 14 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
П.АМГАЛАН ТАНАА

## Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 14 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 14 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **166,769,133.35** | **193,419,917.62** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 2,892,600.00 | 2,022,600.00 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 2,892,600.00 | 2,022,600.00 |
| **3121** | **Төгрөг** | 2,892,600.00 | 2,022,600.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 2,892,600.00 | 2,022,600.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 163,876,533.35 | 191,397,317.62 |
| **351** | **Түүхий эд материал** | 125,053,191.35 | 153,490,319.62 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 124,865,491.35 | 152,661,419.62 |
| 35130 | Эм боох материал | 187,700.00 | 828,900.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 38,823,342.00 | 37,906,998.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,303,420.00 | 7,407,766.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 32,519,922.00 | 29,291,232.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 1,208,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,064,025,837.29** | **8,097,038,101.50** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 8,064,025,837.29 | 8,097,038,101.50 |
| **392** | **Биет хөрөнгө** | 7,577,025,837.29 | 7,608,725,601.51 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 6,476,874,489.00 | 6,641,861,261.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (283,254,409.82) | (441,973,433.90) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 426,429,251.92 | 459,639,333.12 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (277,930,308.98) | (289,849,405.26) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 186,510,633.92 | 183,778,188.92 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (155,630,871.40) | (157,707,815.02) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 1,093,291,115.00 | 1,093,291,115.00 |
| 39217 | Ном | 110,735,937.65 | 119,686,357.65 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 487,000,000.00 | 488,312,499.99 |
| 39301 | Програм хангамж | 1,654,860.00 | 3,054,860.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,654,860.00) | (1,742,360.01) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 487,000,000.00 | 487,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **8,230,794,970.64** | **8,290,458,019.12** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,856,154,593.27** | **3,915,817,641.75** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,856,154,593.27 | 3,915,817,641.75 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (698,716,987.67) | (639,053,939.19) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (698,716,987.67) | (697,316,987.67) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 58,263,048.48 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,554,871,580.94 | 4,554,871,580.94 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,856,154,593.27** | **3,915,817,641.75** |

## 2.3 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,430,711,051.60** | **2,383,274,299.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **148,212,051.60** | **957,120.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 148,212,051.60 | 957,120.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 148,212,051.60 | 957,120.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 22,010,262.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 72,000.00 | 957,120.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 126,129,789.60 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,282,499,000.00** | **2,382,317,179.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,191,898,200.00 | 2,220,926,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,191,898,200.00 | 2,220,926,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8,133,700.00 | 76,564,979.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 51,068,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 828,800.00 | 500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 90,000.00 | 24,961,979.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,214,900.00 | 35,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 82,467,100.00 | 84,825,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 82,467,100.00 | 84,825,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,462,990,761.15** | **2,514,035,734.19** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,462,990,761.15** | **2,514,035,734.19** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,360,556,210.65 | 2,387,346,346.84 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,851,523,646.50 | 1,839,545,189.65 |
| 210101 | Үндсэн цалин | 1,691,097,008.00 | 1,041,822,311.29 |
| 210102 | Нэмэгдэл | - | 661,317,508.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 1,953,957.76 |
| 210104 | Урамшуулал | 160,426,638.50 | 134,451,412.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 230,439,558.00 | 239,031,805.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 159,613,743.77 | 154,341,808.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,551,449.74 | 20,682,969.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,786,747.71 | 16,694,951.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,288,017.36 | 4,302,005.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,199,599.42 | 43,010,072.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,837,943.00 | 59,936,369.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,125,321.00 | 8,557,110.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,633,688.00 | 33,318,372.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 20,078,934.00 | 18,060,887.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,459,882.00 | 44,230,310.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,355,982.00 | 13,070,304.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 447,726.00 | 1,003,712.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 72,700.00 | 127,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,860,890.00 | 416,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,145,965.00 | 11,655,782.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8,576,619.00 | 17,956,712.40 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,406,990.00 | 553,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 536,990.00 | 553,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 870,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,216,800.00 | 12,788,982.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,216,800.00 | 12,788,982.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 828,800.00 | 92,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 828,800.00 | 92,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,496,800.00 | 2,651,550.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 968,500.00 | 2,170,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,528,300.00 | 481,550.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 175,345,791.15 | 188,516,140.79 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 385,000.00 | 850,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,063,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 174,960,791.15 | 186,602,640.79 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 102,434,550.50 | 126,689,387.35 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,186,692.00 | 95,899,200.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 124,792.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 43,461,900.00 | 92,014,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,600,000.00 | 3,885,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 12,216,357.00 | 16,542,061.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,216,357.00 | 16,542,061.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 43,031,501.50 | 14,248,126.35 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 43,031,501.50 | 14,248,126.35 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(32,279,709.55)** | **(130,761,435.19)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(32,279,709.55)** | **(130,761,435.19)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,333,403,509.00** | **2,398,046,906.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **22,082,262.00** | **957,120.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 22,082,262.00 | 957,120.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 22,082,262.00 | 957,120.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 22,010,262.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 72,000.00 | 957,120.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,311,321,247.00** | **2,397,089,786.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,191,898,200.00 | 2,220,926,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,191,898,200.00 | 2,220,926,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8,133,700.00 | 76,564,979.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 51,068,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 828,800.00 | 500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 90,000.00 | 24,961,979.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,214,900.00 | 35,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 82,467,100.00 | 84,825,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 82,467,100.00 | 84,825,300.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 28,822,247.00 | 14,772,607.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 28,822,247.00 | 14,772,607.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,334,372,009.00** | **2,364,805,706.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,334,372,009.00** | **2,364,805,706.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,203,240,003.50** | **2,223,343,711.65** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,851,573,646.50 | 1,839,545,189.65 |
| 210101 | Үндсэн цалин | 1,295,859,630.00 | 1,041,822,311.29 |
| 210102 | Нэмэгдэл | 414,804,727.50 | 661,317,508.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 882,400.00 | 1,953,957.76 |
| 210104 | Урамшуулал | 140,026,889.00 | 134,451,412.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 230,439,558.00 | 239,031,805.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 161,973,567.00 | 154,341,808.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,116,573.00 | 20,682,969.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,693,298.00 | 16,694,951.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,423,275.00 | 4,302,005.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,232,845.00 | 43,010,072.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,837,943.00 | 59,936,369.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,231,316.00 | 8,557,110.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,633,688.00 | 33,318,372.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,972,939.00 | 18,060,887.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210304 | Байрны түрээс | | |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,704,751.00 | 15,044,280.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,459,300.00 | 1,497,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 447,726.00 | 1,003,712.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,942,000.00 | 192,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,607,490.00 | 666,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,248,235.00 | 11,684,568.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,449,650.00 | 4,148,150.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 657,900.00 | 1,482,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,791,750.00 | 2,666,050.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,627,700.00 | 43,842,978.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,214,900.00 | 6,220,746.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,412,800.00 | 37,622,232.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 828,800.00 | 92,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 828,800.00 | 92,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,496,800.00 | 2,586,550.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 968,500.00 | 2,170,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,528,300.00 | 416,550.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,281,155.00 | 19,115,790.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 385,000.00 | 850,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,896,155.00 | 18,265,790.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **131,132,005.50** | **141,461,994.35** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 75,884,147.00 | 110,671,807.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 28,822,247.00 | 14,772,607.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 43,461,900.00 | 92,014,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,600,000.00 | 3,885,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 12,216,357.00 | 16,542,061.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,216,357.00 | 16,542,061.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 43,031,501.50 | 14,248,126.35 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 43,031,501.50 | 14,248,126.35 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(968,500.00)** | **33,241,200.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **34,111,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **34,111,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 34,111,200.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 34,111,200.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(34,111,200.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (968,500.00) | (870,000.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 2,892,600.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 2,892,600.00 | 2,022,600.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 4,374,640,377.37 | 4,554,871,580.94 | (666,562,070.12) | 8,262,949,888.19 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,374,640,377.37** | **4,554,871,580.94** | **(666,562,070.12)** | 8,262,949,888.19 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (32,154,917.55) | (32,154,917.55) |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,374,640,377.37** | **4,554,871,580.94** | **(698,716,987.67)** | 8,230,794,970.64 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **4,374,640,377.37** | **4,554,871,580.94** | **(698,716,987.67)** | 8,230,794,970.64 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 1,400,000.00 | 1,400,000.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,374,640,377.37** | **4,554,871,580.94** | **(697,316,987.67)** | 8,232,194,970.64 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 58,263,048.48 | 58,263,048.48 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,374,640,377.37** | **4,554,871,580.94** | **(639,053,939.19)** | 8,290,458,019.12 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2306952200.00 | 2275919753.65 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2306952200.00 | 2274990553.65 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2211380800.00 | 2179961353.65 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1839611400.00 | 1839545189.65 |
| 210101 | Үндсэн цалин | 1155417500.00 | 1041822311.29 |
| 210102 | Нэмэгдэл | 544049900.00 | 661317508.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5920700.00 | 1953957.76 |
| 210104 | Урамшуулал | 134223300.00 | 134451412.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 246004700.00 | 239031805.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 172420300.00 | 154341808.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18396100.00 | 20682969.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14716900.00 | 16694951.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3679200.00 | 4302005.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36792200.00 | 43010072.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 76462200.00 | 59936369.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10485300.00 | 8557110.00 |
| 210302 | Түлш, халаалт | 44853700.00 | 33318372.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21123200.00 | 18060887.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16755700.00 | 13548280.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 1462200.00 | 1462200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,003,800.00 | 1,003,712.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,169,700.00 | 192,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 584,900.00 | 416,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,535,100.00 | 10,473,568.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,049,600.00 | 3,895,700.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,482,100.00 | 1,482,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,567,500.00 | 2,413,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,363,100.00 | 8,346,870.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,363,100.00 | 8,346,870.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 92,600.00 | 92,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 92,600.00 | 92,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 416,600.00 | 416,550.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 416,600.00 | 416,550.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,624,900.00 | 15,147,990.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,427,500.00 | 850,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,197,400.00 | 14,297,990.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 95,571,400.00 | 95,029,200.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 95,571,400.00 | 95,029,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 92,014,200.00 | 92,014,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,557,200.00 | 3,015,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **929,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 929,200.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 929,200.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,307,284,600.00 | 2,305,839,320.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,221,126,300.00 | 2,220,926,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,221,126,300.00 | 2,220,926,900.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 84,825,300.00 | 84,825,300.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 84,825,300.00 | 84,825,300.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,333,000.00 | 87,120.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,333,000.00 | 87,120.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **2,892,600.00** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **2,022,600.00** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **76,564,358.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **43,382,358.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 43,382,358.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,496,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 35,000.00 |

| | | |
|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,211,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 252,450.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 252,450.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 35,496,108.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,220,746.00 |
| 210604 | Урсгал засвар | 29,275,362.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,170,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,170,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,967,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,967,800.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **33,182,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 33,182,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 33,182,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 76,564,979.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 76,564,979.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 51,068,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 24,961,979.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 14 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бүртгэл санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ , газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн 14 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн 14 дүгээр сургууль нь Сургуулийн үзэл баримтлалд нийцүүлэн бие даасан хөтөлбөрийг боловсруулж, ЕБС-н сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмжийг хэрэгжүүлэн хүүхэд бүр өөрийн сонголтоор хөгжих, багш ажилчид ангид аюулгүй орчин бүрдүүлж, суралцагчдын сурах үйлийг дэмжиж, хоцрогдлыг нөхөх, арилгахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж, сургалт, үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм баримталж, ажилтны ёс зүй харилцааны хэм хэмжээг мөрдөн ажиллахад оршино гэсэн зорилго дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТхууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн 14 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **Дунд** гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 2,306,952.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 23,069.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 16,148.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн 14 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,663.1 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 2,892.6 | 2,022.6 | 870.0 |
| Авлага | | | |
| Бараа материал | 163,876.5 | 191,397.3 | 27,520.8 |
| Үндсэн хөрөнгө | 8,064,025.8 | 8,097,038.1 | 33,012.3 |
| **Нийт хөрөнгө** | **8,230,794.9** | **8,290,458.0** | **59,663.1** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 8,230,794.9 | 8,290,458.0 | 59,663.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **8,230,794.9** | **8,290,458.0** | **59,663.1** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл ахмадын дансны үлдэгдэл бөгөөд 870.0 мянган төгрөгөөр буурсан буюу 2,022.6 мянган төгрөгийн үлдэгдэл байгаа нь 30 ахмаддаа ахмадын баяраар 29.0 мянган төгрөгийг картын дансанд нь шилжүүлсэн байна.

Авлага, Өр төлбөрийн  данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 191,397.3 мянган төгрөг болж 27,520.8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын 34,379.3 мянган төгрөгийн зүйлсийг худалдан авсан, БСУГ-аас 4,825.4 мянган төгрөгийн химийн кабинетын бодис үнэ төлбөргүй орж ирсэн, 11,898.8 мянган төгрөгийн материал акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,097,038.1 мянган төгрөг болж 33,012.3 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант оны элэгдлийн зардал 186,602.6 мянган төгрөг хэдий ч үнэ төлбөргүй хүлээн авсан нийт 177,292.4 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 34,111.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмж бүртгэсэн тул үндсэн хөрөнгийн данс өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,290,458.0 мянган төгрөг болж 59,663.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн 14 дүгээр сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 141,587.7 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар өссөн байна. Өмнөх оноос орлого өссөн нь дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, нэмэлт санхүүжилтийн дансны орлого, хандив тусламжийн дансны орлогоос шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 51,045.0 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,433,600.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,433,600.5 мянган төгрөгөөр тооцон Боловсрол соёл урлагийн газарт хүргүүлсэн. Тайлант онд 2,136,934.6 төгрөгийн төсөв батлагдаж, төсвийн хуваарь ирүүлсэн байна. /2021 оны 01 сар/.

Баталж ирүүлсэн төсвийн хуваарийг 12 сард тодотгож 168,817.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,305,752.2 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2,305,752.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 1,200.0 мянган төгрөгийн цайны газрын түрээсийн төлбөрийн орлогыг төлөвлөснөөс, 2,220,926.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 84,825.3 мянган төгрөгийг орон нутгийг төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,220,926.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийг төсвөөс 84,825.3 мянган төгрөг, цайны газрын түрээсийн төлбөрийн орлого 957.1 мянган төгрөг, нийт 2,306,709.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,275,919.7 мянган төгрөгийг зарцуулж, 30,790.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,275,919.7 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 16,525.8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 6,972.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,476.9 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 3,207.4 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансны 76,564.3 мянган төгрөгийн гүйлгээ тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн 14 дүгээр сургуулийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаандаа оруулсан 148 талбарын мэдээлэл, хугацаа хоцроосон нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдэгдэл 1 талбарын мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 21,556.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,300.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 1,986.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож хэрэгжилт 100% биелсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн 14 дүгээр сургуулийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20,859.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 17,956.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 516.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,385.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Бараа материалын тодруулга тайланд 17,956.6 мянган төгрөгийн акталсан бараа материалыг худалдан авсан ангиллаар толилуулсан, санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлийг үг үсэг, утга найруулга, мэдээллийн алдаатай бэлтгэсэн байна. Аудитын явцад залруулав.

### 4.3 Албан шаардлага

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн болон төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрч өөрийн санаачилгаар ажлаас чөлөөлөгдсөн багш, үйлчлэгч нарыг дахин түр авч ажиллуулсан ба албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгохдоо багш, үйлчлэгч нарт 516,767.6 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Энэ нь “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.2-д “Энэ журмын 4.1-д заасан албан хаагч гэдэгт сургалтын байгууллагын төсвөөс цалинждаг орон тооны ажилтан хамаарна” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Зардлын данстай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

"Би багш" үндэсний контентийн шилдэг 4-т орсон багшид олгосон суурин комьпютерийг Үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмж дансанд бүртгээгүй, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг худалдан авснаар бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 100 дугаар тушаалын "Маягт аргачлал батлах тухай" Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл ҮХ-1-ийг хангахгүй байна.

1.2 <u>Өгсөн зөвлөмж</u>

Үндсэн хөрөнгийн бүртгэл, хөтлөлд зарцуулалтаар тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | 14 дүгээр сургууль | 3 | 20,859.1 | 1 | 17,956.6 | | | 1 | 516.7 | 1 | 2,385.8 |
| **Дүн** | | **3** | **20,859.1** | **1** | **17,956.6** | | | **1** | **516.7** | **1** | **2,385.8** |